



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар Н/Н

Шивээговь сум

“Урд гэр байрны худаг цахимжуулах”  
ажлын гүйцэтгэлийг хүлээн авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 271 дүгээр “Төрийн болон орён нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Урд гэр байрны худаг цахимжуулах” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Дэлгэрдалай (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Алтанцэцэг (Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын ХАБЭА-н инженер)

Ц.Өлзийбуян (2 дугаар багийн иргэн)

2. Урд гэр байрны ухаалаг худгийн тоног төхөөрөмжийг Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал (Ш.Чинболд)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн техник тоног төхөөрөмжийг акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

